



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Мандалговь

“Эрүүл мэндийн байгууллагын соёлыг  
төлөвшүүлэх” жил болгон зарлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Дүрэх батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406, 2015 оны 189 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орчин үеийн хөгжлийн чиг хандлага, хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага бүр үйл ажиллагаандаа шинэчлэл өөрчлөлтийг хийх шаардлагатай уялдуулан 2022 оныг “Эрүүл мэндийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх жил” болгон зарласугай.

2. “Эрүүл мэндийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх жил”-ийн ажлын төлөвлөгөөг батлуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж, биелэлт үр дүнг тооцон ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан), Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Л.Ганбат), Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (Б.Саруулцэцэг), эмнэлэг эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. “Эрүүл мэндийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх жил”-ийн ажлын явцын (6 дугаар сарын 30)-нд болон гүйцэтгэлийн (12 дугаар сарын 20)-нд хяналт шинжилгээ үнэлгээг хийж санал санаачлагатай ажилласан эмнэлэг, эрүүл мэндийн төвийг шалгаруулан урамшуулах ажлыг зохион байгуулахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан), Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн ( П.Оюунчимэг) нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Алтантөгс* Б.АЛТАНТӨГС

